



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2004 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 26

Дархан

ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3, 6 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төлөвлөгөө, төсөвт тусган хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Хаянхярваа/-д даалгасугай.

ДАРГА
НАРИЙН БИЧГИЙН,
ДАРГА

Л.ГҮНЧИН
Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ

"Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих" аймгийн
ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Дархан-Уул аймгийн эрчимжсэн мал аж ахуйн өнөөгийн байдал

Манай улсын хотжих үйл явц улам гүнзгийрэхийн зэрэгцээ эдгээр хотуудын хүн амыг хүнсээр хангах зорилгоор таримал тэжээлийн үйлдвэрлэл эрхлэх боломжтой бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх зорилтын дор тус аймагт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн бааз суурь тавигдаж, энэ нь аймгийн эдийн засгийн хөгжилд тодорхой нөлөөлж байсан билээ.

Дархан-Уул аймагт саалийн механикжсан ферм 2, 100 мэгжний гахайн ферм, нарийн, нарийвтар ноост хонины 5 цогцолборт эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг технологийн дагуу эрхэлж, эдгээрт сүүний чиглэлийн 1000 гаруй үнээ, 25.0 мянга гаруй толгой нарийн нарийвтар ноост хонийг өсгөж, гахайн тоо толгойг 17.0 мянган толгойд хүргэж, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамжинд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл онцгой үүрэг гүйцэтгэж байлаа.

Хүн ам ихээр төвлөрөн суурьшсан хот газарт зайлшгүй хэрэгцээтэй байсан эрчимжсэн мал аж ахуйн цогцолборууд зах зээлийн нөхцөлд өртөг, зардлаа даахгүйгээс уналтанд орж, тараан жижиглэж, хувьчилсан боловч тэдний эрчимжилтийг хангаж байсан нөхцлийг хэвээр хадгалж чадаагүй, үржлийн эх сүрэг болон тэжээлээр хангах, мэргэшсэн ажилчин, мэргэжилтэнг ажиллуулах боломж бага байснаас эрчимжсэн мал аж ахуйн аятай хэлбэр бүрдэж чадаагүй нь дээрх мал аж ахуйдыг уналтанд хүргэж, арвин ашиг шимт цэвэр, эрлийз үүлдрийн малын тоо эрс буурсан юм.

1990 онд аймгийн нийт малын 20.3 хувийг цэвэр, эрлийз үүлдрийн мал эзэлж байсан бол 1995 онд дөнгөж 4.1 хувийг эзлэх болсон билээ. 1990 онд сүүний чиглэлийн симменталь үхэр 2.9 мянган толгой, нарийн, нарийвтар ноост Хангай, Орхон хонь 19.8 толгой байсан бол 1995 онд симменталь үхрийн тоо 2 дахин, нарийн, нарийвтар ноост хонины тоо 5.6 дахин буурсан байна.

Хүн амын хүнсний хангамжинд онцгой ач холбогдол бүхий гахай, шувууны мал аж ахуйд өсөлт, төлөрхөг чанараар муу, давжаа гахай, амьдрах, өндөглөх чадвараар муу шувуу сүрэгт зонхилон, олон найрлагат тэжээлийн үнэ өсч, ховордсоноос эдгээр мал аж ахуйдын үр өгөөж муудаж, уналтанд орсон.

Бэлчээр, нутгийн хүрэлцээ жил ирэх бүр багасаж, хүн амын хүнсний хэрэглээ байнга өсөн нэмэгдэж байдаг аймгийн бодит нөхцөлд мал аж ахуйг эрчимжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, малын биологийн тогтвортой өсөлтийг ханган, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, мал үржлийн ажлын чанарын сайжруулах, мал аж ахуйн материаллаг бааз, тэжээлийн хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг сэргээж, үр ашгийг дээшлүүлэх зорилтыг гол чиглэл болгон хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Мал аж ахуйг эрчимжүүлэх үндсэн нөхцөл болох малын үүлдэрлэг байдлыг сайжруулан, ашиг шимийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд одоо байгаа цэвэр,

эрлийз малыг бүртгэн тоолох, малыг үржүүлэх үржлийн чиглэлийг тогтоон өгч, малын үүлдэр, угсааг сайжруулахад чиглэгдсэн мал эрлийзжүүлгийн ажлыг эрчимжүүлэх, хээлтүүлэгчийн чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна.

Дархан-Уул аймагт 2003 оны жилийн эцэст мал бүхий 2.9 мянган өрхөд 122.3 мянган толгой мал тоологдлоо.

2003 оны жилийн эцсийн дүнгээр тус аймагт Монгол Улсад үржүүлж байгаа 50 гаруй цэвэр, эрлийз үүлдрийн болон нутгийн шилмэл омог, хэвшлийн малаас 21 үүлдэр, омог, хэвшлийн 22.2 мянган толгой мал тоологдсоны 66.7 хувийг цэвэр үүлдрийн, 30.7 хувийг эрлийз үүлдрийн, 2.6 хувийг нутгийн шилмэл омгийн мал эзэлж байна.

2003 онд 102 өрхөд гахайн аж ахуйг, 168 өрхөд шувууны аж ахуйг, 24 өрхөд зөгийн аж ахуйг, 2 өрхөд үслэг амьтан туулайн аж ахуйг хөгжүүлж, эдгээрт 723 толгой гахай, 4218 толгой шувуу, 146 бүл зөгий 112 толгой туулайг тус тус өсгөж байна. Шувууны тоо толгой өнгөрсөн оноос 2 дахин өсөж, уг аж ахуй сэргэх хандлагатай байна.

Малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, жил бүр малд шаардлагатай тэжээлийн хэрэгцээг тооцсоны үндсэн дээр мал бүхий баг, аж ахуйн нэгж, иргэдэд хадлан, тэжээл бэлтгэлийн даалгаврыг өгч, хяналт тавин ажиллуулсанаар жил бүр 180-20.7 мянган тонн тэжээлийн нэгж, үүний дотор 400 гаруй мянган тонн байгалийн хадлан бэлтгэж, нийт малын 54.0-76.0 хувийг байран ба нэмэгдэл тэжээлд оруулах нөхцлийг бүрдүүлж, нэг хонин толгойд 45.2-48.2 кг тэжээл ноогдож байна.

Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах шаардлага. Үндэслэл

Мал аж ахуйд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний дүнд үйлдвэрлэл сэргэж байгаа боловч бэлчээрийн даацын хэтрэлт, мал аж ахуйн материаллаг баазын хангалтгүй байдлаас болж малаас авах үр өгөөж төдийлэн сайжрахгүй, товарлаг мал аж ахуйн зохистой хэлбэр бий болж чадахгүй байна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт мал, малчин өрхийн тооны өсөлт, хэт төвлөрөл, баруун аймгаас төв суурин газрыг чиглэсэн хүн, малын нүүдэл, бэлчээрийн ашиглалт, хөдөлгөөнт байдлын өөрчлөлт, бэлчээрийн газрын зориулалт ба ашиглалтыг өөрчлөх, бэлчээрийн усан хангамжийн байдал, усны эх үүсвэрийн дутагдал, ургац хураалт ба улирлын бэлчээр ашиглалтын зөрчил зэрэг хүчин зүйлүүдийн улмаас жил бүр 2.5 га цөлжилтийн хүчтэй элэгдэлд орж, 14.0-15.0 мянган га бэлчээр талхлагдаж, бэлчээрийн ургамлын бүтэц өөрчлөгдөн мал сүрэг биологийн хэрэгцээт шим тэжээлт бодисоор хангагдаж чадахгүйд хүрээд байна.

1996 онд 100 га бэлчээрт ноогдох мал 181 хонин толгой байсан бол 2003 онд 226 толгой болж, энэ нь төвийн бүсийн дунджаас 7.5 дахин, улсын дунджаас 5.9 дахин илүү байна. Нэг хонин толгойд 0.45 га бэлчээр оногдож байгаагаас үзэхэд бэлчээрийн өвс, ургамлын хэнзлэлтийг оруулан тооцоход л бэлчээрийн даац 2.9 дахин хэтэрсэн байна. Бэлчээрийн бодит хангамж аймгийн хэмжээгээр дөнгөж 39.8 хувьтай байна. Сумдаар авч үзвэл, Хонгор суманд 106.9, Орхон суманд 46.8, Дархан суманд 1.9, Шарын гол суманд 10.8 хувьтай байна.

Бэлчээрийн хомсдол хамгийн их байгаа Дархан суманд малтай өрхийн 73.3 хувь, нийт малын 49.3 хувь нь хот орчимд, тухайлбал, Дархан хотын нутаг дэвсгэрт байна. Сумын хэмжээгээр нэг хонин толгойд 0.02 га бэлчээр ноогдож байгаа нь тухайлбал, уг суманд хот орчмын цөөн тооны мал бүхий эрчимжсэн суурин хэлбэрийн мал аж ахуйг хөгжүүлэхийг зайлшгүй шаардаж байгаа юм. Малчин өрхийн хэт жижгэрсэн, тархай бутархай байдал, мал аж ахуйн материаллаг баазын хангамж муу, мал аж ахуйн эрчимжилтийн арга, технологийг малчид эзэмшиж чадахгүй байгаа зэрэг нь мал аж ахуй эрхлэгчдийн чадавхийг доройтуулж, байгалийн ялиггүй бэрхшээлийн өмнө арчаагүй байдалд оруулж байна.

Өөрчлөгдөж буй амьдралын нөхцөл, хүн амын өсөлттэй холбоотойгоор сүүлийн жилүүдэд 1 хүнд ноогдох мах, сүү, цагаан идээний хэмжээ багасч байгаа нь мал аж ахуйн бүтээгдэхүүний хурдавчилсан өсөлтийг шаардаж байна.

1996 онд УИХ-аас баталсан "Төрөөс хөдөөгийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл"-д "...Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн үндсэн загвар нь хот суурингийн болон дэд бүтэц бүхий газарт эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлж, алслагдсан нутаг бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг эрхлэх явдал мөн" гэж заасны дагуу бэлчээрийн даац хэтэрсэн, хүн амын хүнсний хэрэгцээ өсөн нэмэгдэж байдаг манай аймгийн нөхцөлд газар тариалантай зөв хосолсон, эрсдэл багатай мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь чухал нөлөөтэй байгаа билээ.

Газар тариалангийн төв бүсэд оршдог, дэд бүтцийн хөгжил сайтай, малын тэжээлийн бааз суурийг бүрдүүлэх, худаг, усаар хангах боломж сайтай зэрэг олон давуу талтай учир мал аж ахуйг хөтлөх өвөг, дээдсийн үеэс уламжлан ирсэн туршлагын суурин дээр түүнийг эрчимжүүлэх арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэхийн зэрэгцээгээр эрчимжсэн мал аж ахуйн фермерүүд, аж ахуйдн шинээр бий болгох арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагын үүднээс энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилгууд

3.1. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл, баримтлалд нийцүүлэн аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг газар тариалантай зөв хослуулан, эрчимжүүлэн хөгжүүлэх цогц арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлсэнээр бүсийн тулгуур төвийн бэлчээрийн даацад тохирсон, суурин, хагас суурин хэлбэрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн загварт шилжүүлж, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлсэнээр хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж, чанарыг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1. Бүсийн тулгуур төвийн нөхцөлд тохирсон эрчимжсэн мал аж ахуйн зохистой бүтэц, хэлбэрийг судлан, загвар аж ахуйдыг бий болгож, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх чиглэлээр сургалт, сургалчилгааг зохион байгуулах.

3.2.2. Мал аж ахуйг эрчимжүүлэх, суурин хэлбэрийн аж ахуйд аажмаар шилжүүлэх хөрөнгө, санхүү, технологийн цогц арга хэмжээг үе шаттайгаар авч эрчимжсэн мал аж ахуйн чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

4.1. Энэхүү хөтөлбөрийг 2004-2015 оныг дуусталхи хугацаанд жил бүрийн ажлын төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ Үүнд :

4.2.1. Эхний шат - 2004-2008 он: Төвийн тулгуур бүсийн нөхцөлд тохирсон мал сүргийг цаашид өсгөх чиглэлийг тодорхойлон, арвин ашиг шимт цэвэр үүлдрийн мал, амьтныг үржүүлэн, үржлийн малын бааз, суурийг бий болгон, эрчимжсэн мал аж ахуйн эхлэлийг тавьж, загвар аж ахуйдыг бий болгон, сурталчилах.

4.2.2. Хоёр дахь шат - 2009-2015: Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг бүхий л талаар дэмжиж, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, тэжээлийн баазыг өргөтгөн, мал аж ахуйн материаллаг баазын хангамжийг сайжруулсанаар аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийг суурин, хагас суурин маллагаанд шилжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрыг чиглэл, арга зүйгээр хангаж, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Стратеги төлөвлөлт. бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс хүлээнэ.

5.2. Аймаг, сумдын Засаг даргын дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий Орон тооны бус зөвлөлийг байгуулан ажиллуулна. Уг зөвлөл нь дараахь үйл ажиллагааг явуулна.

5.2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын жил бүр нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулан, биелэлтийг гаргаж, үр дүнг тооцно.

5.2.2. Хөтөлбөрт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явцад газар, хэлтэс, албад агентлагуудын ажлыг уялдуулан зохицуулна.

5.2.3. Хөтөлбөрт шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцон, батлуулж хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаар санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт

6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана.

6.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж олгох хөрөнгө

6.2. Урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл

6.3. Олон улсын болон гадаадын байгууллагын хөрөнгө оруулалт, зээл тусламж

6.4. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж

6.5. Тухайн иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

7.1. Хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх хүчин зүйлүүд болох арвин ашиг шимт үржлийн малын болон малын тэжээлийн баттай бааз суурь, найдвартай цахилгаан хангамж, тээврийн хэрэгслэл ба хөдөлгөөнт төхөөрөмжийн хангамж, усан хангамжийг бий болгох, мал аж ахуйг механикжуулан, үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх, мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зэрэгт чиглэгдсэн хөрөнгө, санхүү, технологийн цогц арга хэмжээг зохион байгуулна.

7.1.1. Хөтөлбөрийн 3.2.1-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

7.1.1.1. Аймгийн бэлчээрийн төлөв байдлыг тогтоож, даацыг зөв тодорхойлсоноор газар тариалантай хосолсон, эрсдэл багатай эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн оновчтой хэлбэр, малын төрөл, тоо хэмжээний зохистой бүтцийг боловсруулан, сурталчилна.

7.1.1.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн ашиг орлогын нэмэгдүүлэхэд шинэ арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллагуудад судалгаа, шинжилгээний захиапга өгч, тэдэнтэй болон мал аж ахуйн мэргэжилтнүүд, үйлдвэрлэгчидтэй хамтран ажиглана.

7.1.1.3. Орон нутгийн хөгжлийн төвийн онцлогт тулгуурлан Дархан суманд /хот орчим/ сүүний, махны үхэр, гахай, шувууны аж ахуйдыг, Хонгор суманд махноосны хонины, сүүний болон махны үхрийн, гахай, шувууны, Орхон суманд сүүний үхрийн гахай, шувууны, Шарын гол суманд сүүний үхрийн, гахайн аж ахуйдыг тус тус хөгжүүлнэ.

7.1.1.4. Дээрхи чиглэлээр Хонгор суманд 5, Орхон суманд 3, Шарын гол суманд 3, Дархан суманд 4 загвар аж ахуйг байгуулахад Засгийн газрын болон орон нутгийн хөнгөлөлттэй зээл, тусламжийг үзүүлнэ.

7.1.1.5. Арвин ашиг шимт малыг нутагшуулан хэрэгцээний буюу "цус шингээх" эрлийжүүлэг хийж, ашиг шимээр давуу эрлийз малыг бий болгох замаар сүү болон сүү-махны үхэр, мах-ноосны чиглэлийн хонь, мах-өөхний чиглэлийн гахай, өндөг-махны чиглэлийн шувууны тоо толгойг өсгөж, эдгээр малын сүрэл эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үржил, селекцийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1.1.6. Өндөр ашиг шимт мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үрийг гадаадаас авах, иргэд, аж ахуйн нэгжийн хооронд үржлийн материал солилцох, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг бодлогын хэмжээнд зохион байгуулна.

7.1.1.7. Эрчимжсэн мал аж ахуйг үр ашигтай хөтлөх чиглэлээр сургалтуудыг зохион байгуулан эрчимжсэн мал аж ахуйн мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдыг захиалгын дагуу бэлтгэнэ.

7.1.1.8. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэхийн ач холбогдлыг малчид, иргэд, аж ахуй эрхлэгчдэд сурталчилан, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн нийтийн сургалтуудыг зохион байгуулах, гарын авлага, зөвлөмж хэвлүүлэн сурталчилна.

7.1.1.9. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг авах бүхий л боломжийг судлан хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.

7.1.1.10. Малын нөхөн үржих биологийн нөөцийг бүрэн ашиглах, эрчимжүүлэх, мал хээлтүүлгийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх боломжийг судлан, туршин нэвтрүүлнэ.

7.1.1.11. Шинээр барих хашаа, байрны зураг, төсөл, түүнд тавих шаардлагыг орон нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохируулан боловсруулж, малчдад зөвлөмж болгон хүргүүлнэ.

7.1.2. Хөтөлбөрийн 3.2.2-д дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1.2.1. Тэжээл бэлтгэлийн хэмжээг 2003 оны түвшингээс 40.0 хүртэл хувиар нэмэгдүүлэн, тэжээлд хамруулах малын тоог өсгөх зорилгоор нэг хонин толгойд 60 кг-аас доошгүй тэжээл бэлтгэх түвшинд хүргэх, тэжээлийн бүтцэд чанарын өөрчлөлт гаргаж, хүчит болон биологийн гаралтай тэжээлийг нэмэгдүүлэх технологийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7.1.2.2. Өвс, тэжээл бэлтгэх шинэ техник, технологийг судлан, тэжээлийн үйлдвэр байгуулан ажиллуулах санаачилгыг дэмжин, малын болон гахай, шувууны олон найрлагат тэжээлийн үйлдвэрлэлийг эрс нэмэгдүүлнэ.

7.1.2.3. Эрчимжсэн мал аж ахуйг технологийн зохистой хэмжээгээр эрхлэхэд иргэн, аж ахуйн нэгжүүдэд шаардагдах эдлэн, бэлчээр, хадлангийн талбайг хууль тогтоомжид нийцүүлэн давуу эрхээр эзэмшүүлэн, таримал тэжээл, ногоон тэжээл, даршны ургамал тариалахад нь зориулан газар олгоход дэмжлэг үзүүлнэ.

7.1.2.4. Түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг хагас боловсруулах, малчдын ахуйн хэрэгцээнд зориулан байгалийн болон мал, байгалийн хосолсон гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг зэрэгцүүлэн хөгжүүлнэ.

7.1.2.5. Мэргэжлийн болон Эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран малын нөхөн үржих биологийн нөөцийг бүрэн ашиглах, эрчимжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн мал хээлтүүлгийн дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх боломжийг судлан, туршин нэвтрүүлнэ.

7.1.2.6. Зохих хууль тогтоомжийн дагуу арвин ашиг шимт мал, амьтныг даатгалд хамруулах арга хэмжээг авна.

7.1.2.7. Малчид хоорондоо хөрөнгө хүчээ нэгтгэн хорших, хамтын хөдөлмөр эрхлэх замаар эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэх санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.

7.1.2.8. 500-2000 өндөглөгчтэй тахианы болон 5-30 мэгжний гахайн ферм 10-50 үнээний фермийн технологийн нэг маягийн зураг, төслийг хийлгэх.

7.1.2.9 Хот орчимд 10-20 үнээний жижиг фермерийн аж ахуйдыг боловсруулах үйлдвэрүүдийн хамт байгуулсанаар хүн амын сүүний улирлын тогтвортой хангамжийг нэмэгдүүлнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр гарах үр дүн

8.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараахь үр дүн гарна.

8.1.1. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэгчдэд бодитой дэмжлэг үзүүлсэнээр аймагт сүүний үхрийн 4, махны үхрийн 2, мах-ноосны хонины 2, гахайны 4, шувууны 3 загвар аж ахуйг тус тус байгуулан, Үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

8.1.2. Бэлчээр. хадлангийн талбайд сайжруулалт хийж, ургацыг нэмэгдүүлэх тэжээл үйлдвэрлэлийн технологийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн, хэмжээг нэмэгдүүлэх замаар жил бүр 35.0-40.0 мянган тэжээлийн нэгж бүхий малын тэжээл бэлтгэснээр нийт малыг хагас суурин маллагаанд шилжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

8.1.3. Нийт тэжээлд хүчит болон биологийн гаралтай тэжээлийн эзлэх хувь хэмжээг 22.0 хүртэл хувьд хүргэж, 2003 оны түвшингээс 8 дахин нэмэгдүүлж тэжээлийн бүтцийг сайжруулсанаар суурин ба хагас суурин мал аж ахуйн тэжээллэгийн технологийг мөрдөх нөхцлийг бүрдүүлнэ.

8.1.4 Мал эрлийзжүүлгийн ажлыг эрчимжүүлсэнээр нийт сүрэгт эзлэх цэвэр. эрлийз үүлдрийн болон нутгийн шилмэл омгийн малын тоог 40.0 хүртэл хувьд хүргэснээр малын үүлдэрлэг байдал сайжирч, ашиг шим нь нэмэгдэн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого, амьжиргааны түвшин дээшилнэ.

8.1.5. Гахай, шувуу болон тэжээвэр амьтдын аж ахуйгаас авах үр, өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө, санхүүгийн болон , технологийн асуудлын шийдвэрлэснээр гахай, шувууны мах, өндөгний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн хүнсний багагүй нөөцийг бий болгоно.

8.1.6. Мал аж ахуйн материаллаг бааз суурийг нэмэгдүүлэн, мал маллагааны технологид чанарын өөрчлөлт гарсанаар суурин хэлбэрийн эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх нөхцөл бүрдэж, нийт малын 30 хүртэл хувийг суурин ба эрчимжсэн аж ахуйд шилжүүлнэ

8.1.7 Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлсэнээр аймгийн хүн амын хэрэцээг чанартай бүтээгдэхүүнээр, жигд хангах асуудлыг сайжруулан сүү сүүн бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, махны хэрэгцээний 30.0 хүртэлхи, өндөгний 40.0 хүртэлхи хувийг өөрийн үйлдвэрлэлээр хангана.